



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/180/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Уластай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

᠘᠔᠘4.᠐᠔.᠒᠔᠘ № 43

таний _____ -ны № _____ -т

АСГАТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.БАТБИЛЭГ-Т

ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн даргыг өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй байхад Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар албан тушаалаас чөлөөлж, төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж 23,682.8 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2.2-д "Энэ журмын 1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар тогтоосон үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно", 5.3-д "Төрийн албан хаагч ажил олгогчид өргөдлөө гаргаж, төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа түүнд энэ журамд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Асгат сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 12,228.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 31 төрлийн хөрөнгийг дахин үнэлж, данс бүртгэлд тусгасан байна.

Audit(D)A4-toot/2024

Аудитын гол асуудал

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн золголт, "Завхан-100" арга хэмжээнд оролцоход 4,200.0 мянган төгрөг, Мал эмнэлгийн 100 жилийн ойн хандивт 500.0 мянган төгрөг, "Тэсийн голын нүүдэлчдийн соёлын наадам"-д оролцоход 500.0 мянган төгрөг, Улсын баяр наадмын зардалд 2,400.0 мянган төгрөг, албан бус хэрэгцээнд 282.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Асгат сумын Засаг даргын Тамгын газар нь барилга, байгууламж дансанд бүртгэлтэй уурын зуухны барилга, зочид буудлын барилга, ус цэвэршүүлэх төхөөрөмжийн барилга, Тэрбум мод хөтөлбөрийн мод үржүүлгийн талбайн газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,984,719.1	21,449,540.0
33	АВЛАГА	2,117,179.1	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	27,179.1	-
335	Бусад авлага	2,090,000.0	-
3351	Байгууллагаас авах авлага	2,090,000.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	16,867,540.0	21,449,540.0
354	Хангамжийн материал	16,867,540.0	21,449,540.0
35410	Бичиг хэргийн материал	1,125,800.0	1,650,800.0
35420	Аж ахуйн материал	15,301,740.0	15,301,740.0
35450	Барилгын засварын материал	440,000.0	440,000.0
35470	Бусад хангамжийн материал	-	4,057,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	716,696,521.5	691,478,068.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	716,696,521.5	691,478,068.5
392	Биет хөрөнгө	693,863,644.3	662,353,191.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,839,390.7	460,839,390.7
39202	Хуримтлагдсан элэгдэл	(110,699,964.9)	(120,266,725.2)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,869,800.0	87,869,800.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,537,333.0)	(44,304,883.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	356,865,610.4	356,865,610.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,902,203.2)	(112,608,643.9)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,862,866.0	8,047,716.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,121,466.0)	(1,228,153.5)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,089,252.6	67,089,252.6
39215	Хуримтлагдсан элэгдэл	(38,103,278.2)	(41,651,142.9)
39217	Ном	1,700,970.0	1,700,970.0
393	Биет бус хөрөнгө	22,832,877.2	29,124,877.2
39301	Программ хангамж	3,667,000.0	3,667,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,309,500.0)	(2,589,500.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,475,377.2	28,047,377.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	735,681,240.7	712,927,608.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	421,583,818.3	398,830,186.1
51	Засгийн газрын хувь оролцоо	421,583,818.3	398,830,186.1
512	Хуримтлагдсан үр дүн	240,113,329.1	217,359,696.9
51210	Өмнөх үеийн үр дүн	240,113,329.1	240,113,329.1
51220	Тайлант үеийн үр дүн	-	(22,753,632.2)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,470,489.3	181,470,489.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	421,583,818.3	398,830,186.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339,183,959.1	481,144,797.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,675,959.1	5,650,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	5,675,959.1	5,650,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,650,000.0

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	5,650,000.0
120009	Бусад орлого	5,675,959.1	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	333,508,000.0	475,494,797.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	279,608,000.0	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	279,608,000.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	18,778,397.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	18,778,397.8
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,900,000.0	456,716,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	456,716,400.0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	1,100,000.0	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	52,800,000.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	335,008,983.2	510,159,387.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	335,008,983.2	510,159,387.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,570,390.2	470,265,988.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,850,142.0	292,933,782.9
210101	Үндсэн цалин	135,137,976.0	189,756,761.9
210102	Нэмэгдэл	29,414,641.0	83,176,771.0
210104	Урамшуулал	6,297,525.0	20,000,250.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,500,120.9	36,701,179.1
210201	Тэтгэврийн даатгал	14,770,256.0	25,073,950.8
210202	Тэтгэмжийн даатгал	1,740,871.8	2,933,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,369,177.4	2,238,728.3
210204	Ажилгүйдлийн даатгал	329,073.9	586,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,290,741.8	5,867,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,142,012.0	26,733,848.5
210301	Гэрэл, цахилгаан	3,552,154.6	4,204,776.5
210302	Түлш, халаалт	26,589,857.4	22,529,072.0
2104	Хангамж, бараа материалын зардал	11,986,470.0	38,200,434.0
210401	Бичиг хэрэг	2,046,700.0	6,472,200.0
210402	Тээвэр, шатахуун	8,196,910.0	30,451,234.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,440,000.0	1,277,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	302,860.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,921,200.0	5,794,750.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,600,000.0	-
210604	Урсгал засвар	4,321,200.0	5,794,750.0
2107	Томилолт, зочны зардал	7,505,000.0	8,510,500.0
210702	Дотоод албан томилолт	7,505,000.0	8,510,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,730,605.0	6,903,525.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,622,000.0	5,822,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	397,500.0	396,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,479.0	353,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	22,000.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.0	-
210807	Газрын төлбөр	259,226.0	310,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,934,840.3	54,487,969.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,512,270.0	16,514,516.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.0	533,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,119,170.3	37,440,453.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,438,593.0	39,893,398.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	23,682,800.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,682,800.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,342,842.6	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,342,842.6	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	95,750.4	16,210,598.7
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,750.4	16,210,598.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>4,174,976.0</u>	<u>(29,014,589.4)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,174,976.0</u>	<u>(29,014,589.4)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>280,708,000.0</u>	<u>475,494,797.8</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	280,708,000.0	475,494,797.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	279,608,000.0	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	279,608,000.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	18,778,397.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	18,778,397.8
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,100,000.0	456,716,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	456,716,400.0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	1,100,000.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>287,535,632.0</u>	<u>475,183,755.0</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,535,632.0	475,183,755.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,097,039.0	435,290,356.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,877,321.1	292,933,782.9
210101	Үндсэн цалин	135,219,599.1	189,756,761.9
210102	Нэмэгдэл	29,360,197.0	83,176,771.0
210104	Урамшуулал	6,297,525.0	20,000,250.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,500,120.9	36,674,000.0
210201	Тэтгэврийн даатгал	14,770,256.0	25,046,771.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,740,871.8	2,933,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,369,177.4	2,238,728.3
210204	Ажилгүйдлийн даатгал	329,073.9	586,700.0

210205	Эрүүл мэндийн даатгал	3,290,741.8	5,867,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,242,012.0	26,733,848.5
210301	Гэрэл, цахилгаан	3,604,526.8	4,204,776.5
210302	Түлш, халаалт	25,637,485.2	22,529,072.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,605,110.0	31,767,152.0
210401	Бичиг хэрэг	2,016,200.0	6,997,200.0
210402	Тээвэр, шатахуун	10,148,910.0	23,492,952.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,440,000.0	1,277,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,821,200.0	9,851,750.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,600,000.0	-
210604	Урсгал засвар	4,221,200.0	9,851,750.0
2107	Томилолт, зочны зардал	7,505,000.0	8,510,500.0
210702	Дотоод албан томилолт	7,505,000.0	8,510,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,730,605.0	6,903,525.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,622,000.0	5,822,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	397,500.0	396,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,479.0	353,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.0	-
210807	Газрын төлбөр	259,226.0	310,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,815,670.0	21,915,798.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,512,270.0	21,382,798.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.0	533,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,438,593.0	39,893,398.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	23,682,800.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,682,800.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,342,842.6	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,342,842.6	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	95,750.4	16,210,598.7
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,750.4	16,210,598.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(6,827,632.0)</u>	<u>311,042.8</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,200,000.0	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,200,000.0	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,200,000.0	-
223001	Бусад хөрөнгө	1,200,000.0	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,200,000.0)</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(8,027,632.0)	311,042.8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314,097,422.3	181,470,489.3	197,438,721.1	693,006,632.7
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	314,097,422.3	181,470,489.3	197,438,721.1	693,006,632.7
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	42,674,608.0	42,674,608.0
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314,097,422.3	181,470,489.3	240,113,329.1	735,681,240.7
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	314,097,422.3	181,470,489.3	240,113,329.1	735,681,240.7
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	314,097,422.3	181,470,489.3	240,113,329.1	735,681,240.7
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,753,632.2)	(22,753,632.2)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314,097,422.3	181,470,489.3	217,359,696.9	712,927,608.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,800,872.0	440,505,801.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,800,872.0	440,505,801.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,118,072.0	416,823,001.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,339,800.0	292,933,782.9
210101	Үндсэн цалин	202,943,000.0	189,756,761.9
210102	Нэмэгдэл	90,396,800.0	83,176,771.0
210104	Урамшуулал	-	20,000,250.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,973,900.0	36,674,000.0
210201	Тэтгэврийн даатгал	24,938,300.0	25,046,771.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,933,900.0	2,933,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,200.0	2,238,728.3
210204	Ажилгүйдлийн даатгал	886,700.0	586,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,867,800.0	5,867,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,422,772.0	25,238,563.5
210301	Гэрэл, цахилгаан	2,883,800.0	2,709,491.5
210302	Түлш, халаалт	22,538,972.0	22,529,072.0
2104	Хангамж, бараа материалын зардал	25,741,200.0	25,740,380.0
210401	Бичиг хэрэг	6,873,200.0	6,997,200.0
210402	Тээвэр, шатахуун	16,676,200.0	17,466,180.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,191,800.0	1,277,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,855,400.0	9,851,750.0
210604	Урсгал засвар	9,855,400.0	9,851,750.0
2107	Томилолт, зочны зардал	7,970,800.0	7,970,500.0
210702	Дотоод албан томилолт	7,970,800.0	7,970,500.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,353,000.0	1,953,525.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.0	872,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	409,000.0	396,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	353,700.0	353,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	28,600.0	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	46,400.0	-
210807	Газрын төлбөр	315,300.0	310,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,461,200.0	16,460,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,157,800.0	16,157,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.0	303,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,682,800.0	23,682,800.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,682,800.0	23,682,800.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,682,800.0	23,682,800.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	456,716,400.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	456,716,400.0
132001	Орон нутгийн төсвөөс	-	456,716,400.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	18,467,355.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	18,467,355.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	18,467,355.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,495,285.0
210301	Гэрэл, цахилгаан	-	1,495,285.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,026,772.0
210402	Тээвэр, шатахуун	-	6,026,772.0
2107	Томилолт, зочны зардал	-	540,000.0
210702	Дотоод албан томилолт	-	540,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,950,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,950,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,455,298.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,225,298.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	230,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	18,778,397.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	18,778,397.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	18,778,397.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэл:

- Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын зорилго: Иргэд олон нийтийн санал, санаачилгад тулгуурлан төрийн үйлчилгээг иргэн бүрд шуурхай, жигд хүртээмжтэй, үнэнч шударгаар хүргэж оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх чадварлаг, үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх гэсэн зорилго, зорилт чиг үүргийн хүрээнд ажилладаг байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.9 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Татварын ерөнхий хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Сумын ЗДТГ-ын дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 280,433.2 мянган төгрөгөөр буюу 47.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,117.2	-	(2,117.2)
Бараа материал	16,867.5	21,449.5	4,582.0
Үндсэн хөрөнгө	716,696.5	691,478.1	(25,218.4)
Нийт хөрөнгө	735,681.2	712,927.6	(22,753.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	735,681.2	712,927.6	(22,753.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	735,681.2	712,927.6	(22,753.6)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Өмнөх оны ажиллагсадтай холбоотой 27.2 мянган төгрөгийн, байгууллагаас авах авлага 2,090.0 мянган төгрөгийн авлага барагдсан байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 16,867.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 63,217.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 58,635.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 21,449.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,582.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ч цаашид ашиглагдах боломжтой хөрөнгүүдэд үнэ тогтоож, 12,228.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, жилийн эцэст 691,478.1 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 37,440.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 22,753.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 687,203.0 мянган төгрөг, нийт зарлагыг 687,203.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Урсгал засвар болон нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг хассан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 441,516.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 440,505.8 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна. Баг хорооны цалин 655.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардал 328.0 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	350,746.3	350,718.3	28.0	99.9%
80106	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	49,729.9	49,074.9	655.0	99.2%
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,200.0	872.0	328.0	72.7%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	23,682.8	23,682.8	-	100%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	15,327.8	15,327.8	-	100%
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	830.0	830.0	-	100%
НИЙТ		441,516.8	440,505.8	1,011.0	99.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 18,778.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 18,092.6 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 311.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

<i>/мянган төгрөг/</i>				
№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Халаалтын төлбөр	25,637.5	22,529.1
ДҮН			25,637.5	22,529.1

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Асгат сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 03/22 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөөр сонгож, 735,681.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,035.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.276.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 712,927.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,693.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.020.4 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 44 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд Засаг даргын нөөц хөрөнгөөс Нутгийн зөвлөлийн золголт, "Завхан-100" арга хэмжээнд оролцоход 4,200.0 мянган төгрөг, Мал эмнэлгийн 100 жилийн ойн хандивт 500.0 мянган төгрөг, "Тэсийн голын нүүдэлчдийн соёлын наадам"-д оролцоход 500.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 56,615.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	56,615.8	1	56,615.8	100%
Нийт дүн	1	56,615.8	1	56,615.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 26,296.4 мянган төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

18,672.0 мянган төгрөгийн зардал болон 7,624.4 мянган төгрөгийн бараа материалыг зөв ангилж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ыг зөрчиж, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 33,913.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 282.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 26,031.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж,

7,600.0 мянган төгрөгийн болон газрын нэгдсэн санд бүртгэлтэй газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 33,913.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 23,219.8 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Нөмрөг сумын 100 жилийн ойн арга хэмжээнд оролцохоор 132.0 мянган төгрөгийн, Мал эмнэлгийн тасгийн дарга Улиастай суманд зохион байгуулагдсан Мал эмнэлэг, үржлийн албаны 100 жилийн ойн арга хэмжээнд оролцохоор 150.0 мянган төгрөгийн шатахууныг албан бус хэрэгцээнд зориулалт бусаар зарцуулсан, нийт 282.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн даргыг өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй байхад Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар чөлөөлж, төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон болон нууц хамгаалах ажилтнаар анх удаа томилогдсон Тамгын газрын даргад нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдлийг ажлын ачаалал, хариуцаж байгаа нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацаа зэргийг харгалзалгүй 30 хувиар олгосон зөрчилд 2 албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс Нутгийн зөвлөлийн золголт, "Завхан-100" арга хэмжээнд оролцоход 4,200.0 мянган төгрөг, улсын баяр наадмын зардалд 2,400.0 мянган төгрөг, Мал эмнэлгийн 100 жилийн ойн хандивт 500.0 мянган төгрөг, "Тэсийн голын нүүдэлчдийн соёлын наадам"-д оролцоход 500.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэсэн заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг нөөц хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-тай нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, үрэлгэн зардал гаргахгүй байх;

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй урын зуухны барилга, зочид буудлын барилга, Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн барилга, Тэрбум мод хөтөлбөрийн мод үржүүлгийн талбайн газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй дээрх барилга байгууламжуудын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлыг зөв ангилж бүртгээгүй байна.	1	18,672,0			1	18,672,0	1	18,672,0				
Бараа материалыг зөв ангилж бүртгээгүй байна.	1	7,624,4			1	7,624,4	1	7,624,4				
Дүн	2	26,296,4			2	26,296,4	2	26,296,4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ тоо	Тоо	Дүн
Албан бус хэрэгцээнд шатахуун зарцуулсан	1	282.0	1	282.0								
Нутгийн зөвлөлийн золголт, "Завхан-100" арга хэмжээ, улсын баяр наадам "Тэсийн голын нүүдэлчдийн соёлын наадамд оролцох болон Мал эмнэлгийн	1	7,600.0					1	7,600.0				

100 жилийн ойн хандивт хөрөнгө зарцуулсан байна.												
Тамгын газрын даргад нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдлийг журам зөрчиж олгосон байна.	1	2,348,9			1	2,348,9						
Хөдөө аж ахуйн тасгийн даргыг өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй байхад төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон байна	1	23,682,8			1	23,682,8						
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй барилга байгууламжуу дын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй							1					
Дүн	5	33,913.7	1	282.0	2	26,031.7	2	7,600.0				

АУДИТЫН ТАЙЛАНГ:


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Огноо: 2024-02-23



Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Огноо: 2024-02-23

Ц.ОЮУНСУВД